



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 12

Бүрхээр

Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын тов тогтоох тухай

Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.3, 69.6 дахь заалт, “Могойн гол” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасныг тус тус баримтлан, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хуралдахаар зарлагдсан “Могойн гол ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн тухай” тооллогын комиссын дүн мэдээлэл, тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус компанийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хуульд заасан хувь хэмжээнд хүрээгүй тул хүчин төгөлдөр бус гэж үзэн хурлыг хойшлуулж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дахин хуралдах өдрийг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр товлон, 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 28-р байр, “Роял тауэр” оффисын байранд хуралдахаар тогтоосугай.
2. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хууль, журамд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс (Ж.Батболд)-д даалгасугай.
3. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомж болон компанийн дүрмийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг комиссын дарга (Ж.Батболд), тооллогын комиссын дарга (Л.Шинэцэцэг) нарт даалгасугай.



ДАРГА

Ж.БАТБОЛД